



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠑ оны ᠕ сарын ᠕ өдөр

Дугаар А1496

Улаанбаатар хот

Нийслэлийн хүүхдийн 198 дугаар цэцэрлэгийн
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.7 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/126 дугаар тушаалаар байгуулагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 5,444,227.53 (таван сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга хоёр зуун хорин долоон төгрөг тавин гурван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан эргэлтийн бус хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн хүүхдийн 198 дугаар цэцэрлэг (Т.Азжаргал)-т зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 8 нэр төрлийн нийт 5,444,227.53 (таван сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга хоёр зуун хорин долоон төгрөг тавин гурван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Нийслэлийн Өмчийн харилцааны газарт хүлээлгэн өгөхийг Нийслэлийн хүүхдийн 198 дугаар цэцэрлэг (Т.Азжаргал)-т, татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Т.Оюунтуул)-т даалгасугай.

ДАРГА *В.Оюумаа* В.ОЮУМАА

